

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2024 оны 02 сарын 02 өдөр

№ SR-2024-02

Улаанбаатар хот

2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалт болон Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хооронд явуулсан эчнээ санал хураалтаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банк нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 61.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 19.1%-д хүргэж ажилласан болохыг;
- Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Банкны 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг бэлэн мөнгөөр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
- Монголбанк нь 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-1/1048 тоот албан бичгээрээ Банкинд хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилахыг зөвшөөрсөн болохыг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалт болон Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Хагас жилийн ногдол ашигт нийт 15,527,325,000.00 (арван таван тэрбум таван зуун хорин долоон сая гурван зуун хорин таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 14.75 (арван дөрвөн төгрөг далан таван мөнгө) төгрөг зарлан хуваарилсугай.
- Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийг Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

3. Энэхүү шийдвэр батлагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Банкны ногдол ашгийг бэлэн мөнгөөр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА